

“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар хот

2018 оны 4-р сарын 27

Хурал “Монинжбар” ХК – ийн хурлын танхимд 11:00 цагт эхэллээ.

Хурлаар хэлэлцэх асуудлууд

1. 2017 оны компанийн үйл ажиллагааны тайлан
2. 2017 оны санхүүгийн тайлан
3. 2018 оны төлөвлөгөө
4. Ногдол ашгийн тухай

Хурлын явц:

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Баярсайхан: Хурын дэгийг танилцуулав. Хурлын дэгтэй холбоотой санал хэлэх гишүүд байна уу? Хурлын дэгтэй холбоотой санал өгөх гишүүд **Байхгүй** тул хурлын дэгийг батлав.

- Б.Баярсайхан: Тооллогын комисс оо нэг хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулчих уу. Та бүхэнд ямар санал байна.

Болд: 1 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж болно.

Б.Баярсайхан: За тэгвэл Хурлын нарийн бичиг Н.Энхчулууныг сонгох саналтай байна. Та бүхэн ямар саналтай байна?

Санал нэг байгаа тул Тооллогын комиссоор ТУЗ – ийн Нарийн бичиг Н.Энхчулууныг томилох саналыг 100 хувиар зөвшөөрлөө.

Тооллогын комиссын дарга Н.Энхчулуун ирцийг бүртгэхэд хуралд саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдын 12 148 094,0 ширхэг буюу 76.6% ирцтэй байлаа. /Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав./

Хурлын дэгийн дагуу Хурлын даргад нэр дэвшүүлэх хувьцаа эзэмшигчийг сонгох ёстой. Та бүхэн хэнийг нэр дэвшүүлэх саналтай байна? Өөрөө ч дэвшиж болно, өөр хүнийг ч дэвшүүлж болно.

Цэгмид, Болд: Гүйцэтгэх захирал Б.Баярсайханыг сонгоё гэсэн саналын дагуу ХЭХ – ын даргаар сонголоо.

Б.Баярсайхан - Юуны өмнө та бүхнийг хуралдаа хүрэлцэн ирсэнд баярлалаа. Компанийн тухай хууль болон ТУЗ – ийн 2018 оны 2 – р сарын 28 – ны өдрийн 02 тоот тогтоолоор ХЭХ – ыг 2018 оны 4 – р сарын 27 – ны өдрийн 11:00 цагт хуралдуудах шийдвэр гарсны дагуу хурлын үйл ажиллагаа нээснийг мэдэгдэе.

Хурлын хэлэлцэх асуудал 1

Хурлын дэгийн дагуу үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулав. /Хавсралтад тайланг хавсаргав/

- 2017 онд компани эдийн засгийн хямрал, МУ – д хийгдэж буй бүтээн байгуулалтын санхүүжилттэй холбоотой шинээр ажил гүйцэтгэсэнгүй. 2016, 2017 он дамнаж дэлхийн эдийн засаг төдийгүй Монгол улс санхүүгийн хямралтай байлаа. Ажил хийсэн ч түүнийхээ санхүүжилтийг авч чадахгүй байх, үүнээс үүдэлтэй банк санхүүгийн байгууллагуудаас авсан зээл, зээлийн хүүгээ төлж чадахгүй бараг хар дансанд орох, зээлийн хүүгийн зардал нэмэгдэх гэм мэт компанид нэлээд асуудлууд үүсч байсан. Бид 2017 онд 10 орчим тэрбум төгрөгний тендер шалгаруулалтад оролцсон. Ингэж оролцохдоо 3,5 тэрбум төгрөгийн ажлыг гүйцэтгэхээр шалгарсан боловч гэрээ хийгдэх шатанд энэ ажил маань цуцлагдсан. Цуцлагдсан шалтгаан маань улсын төсвийн орлого тасарсан, санхүүжүүлэх боломжгүй гэсэн үндэслэлээр цуцалсан. Ер нь 2017 онд 300 гаруй тэрбум төгрөгний тендерийг санхүүжүүлэх боломжгүй үүднээс МУ – ын Засгийн

газар цуцалсан. Ийм хүндрэлтэй шалтгаанаас Компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс 2017 онд хийсэн ажилдаа сэтгэл хангалуун бус байгаа.

- 2017 онд Нью Тур ХХК – ийн захиалгатай ажлыг 100 хувь дуусгасан. Бидэнд энэ компани төлбөрөө төлөхгүй байхаар бид 2017 онд хийх жоохон ажил үлдээсэн байснаа гүйцээж хийсэн байгаа.
- Мөн Баянголын амны өргөх насос станцын ажил байгаа бөгөөд санхүүжилт дутуу, хэрэглэгч байхгүй гэсэн шалтгаанаар дуусгаагүй ажил байна.
- Компани санхүүгийн хүндрэлтэй байсан ч цомхотгол хийж зардлаа багасгах аргыг хэрэглээгүй компаниас нэг ч ажилтан халаагүй. Харин бид 2016, 2017 онуудад 60, 30 хувиар сул зогсолт хийсэн байгаа. Үүнтэй холбоотой цалингийн өглөгтэй байгаа.

Болд: Мөнгөө өгдөггүй газруудаас мөнгөө л авах хэрэгтэй дэ.

Б.Баярсайхан: Бид нэг чиглэлийн байгууллага байдаг бөгөөд бүгд өрийн сүлжээнд орчихсон. Манайхаас авлагатай газар нь нөгөө газарт өглөг үүсчихсэн байх жишээний байдаг.

- Үйл ажиллагааны тайлантай холбоотой Гүйцэтгэх удирдлагаас асуух асуулт байна уу?...

За тэгвэл үйл ажиллагааны тайланг “хангалттай” гэж үзэх үү? Бүх гишүүдийн 100%-ийн саналаар хангалттай гэж үзэж тогтоолыг батлав.

Хурлын хэлэлцэх асуудал 2

Г.Өлзийсайхан: 2017 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтэд тодорхой гаргасан байгаа. Гэхдээ товч танилцуулахад манай компани нь тендер баримжаатай үйл ажиллагаа явуулдаг учраас улс орны санхүүгийн байдал, тендер шалгаруулалт явагдсан ч гэрээ байгуулагдах боломж бүрдээгүй зэрэг шалтгаанаас болж 2017 онд ажил гүйцэтгэсэнгүй. Ажилгүй гээд би зүгээр байсангүй. Ажилчдаа халж сольсонгүй. Энэ салбартаа бид нэлээд том аппараттай. 40 гаруй ажилчдын НД – ийг тасралтгүйгээр төлж ирсэн. 2017 онд борлуулалтгүй учраас зардал нэлээд өссөн өөрөөр хэлбэл бид алдагдалтай ажилласан. Ажилчдын цалингийн зардал маань өсөж 270 гаруй сая, хэрэглээний зардал зэрэг маань нэмэгдээд үүнийгээ төлөхийн тулд бид зээл авахаас аргагүй болсон.

Б.Баярсайхан: Ажилчид маань ажилгүй байгаа учраас компаниас дэмжиж БНСУ – д хэд хэдэн инженерүүд, ажилчдыг аялалын визээр ажиллуулах зорилгоор явуулсан байгаа.

Б.Болд: Үл хөдлөхийн татварыг хэр хэмжээгээр төлдөг бэ? Элэгдэлд байшин, тоног төхөөрөмж л орох уу?

Г.Өлзийсайхан: Уг татварыг жилд 3 100 000,0 төгрөг төлдөг. Элэгдэлд байшин барилга, тоног төхөөрөмж маань ордог. Ерөнхийдөө жил жилд бага багаар буураад явчихдаг.

Цэгмид: Та нар энэ жил элэгдэл байгуулсан биз дээ? Элэгдэл байгуулахаар алдагдал бас нэмэгдээд явж байгаа юу?

Г.Өлзийсайхан: Бид элэгдэл байгуулсан байгаа. Үүнтэй холбоотой бас алдагдал нэмэгдээд явж байгаа.

Цэгмид: Асуух зүйл алга байна. Тайланд бүх зүйл тодорхой байна.

Б.Баярсайхан: 2017 оны удирдлагын зардлын бууралт, өсөлтийн талаар тодруулбал?

Г.Өлзийсайхан: Бичиг хэргйн зардал 6% - иар, хэрэглээний зардал 1,3% - иар өссөн байгаа. Ерөнхийдөө зардал гүйцэтгэлээрээ өөрчлөгдсөн зүйл байхгүй. Гол нь цалингийн зардал буурсан байгаа. Мөн элэгдлийн зардал байгаа. Тухай байгуулсан жилээрээ жил болгон буураад явчихна. Шатахууны зардал нь бид ажилтай үедээ бол томилолттой учраас шатахуун өндөр гардаг. Энэ нь багассан байгаа. Тендерт оролцоогүй байгаагаас банкны баталгааны шимтгэлтэй холбоотой багассан байгаа.

Болд: 2018 оны зарлагын төлөвлөгөө байгаа ч орлогын төлөвлөгөө байхгүй байна? Энэ ямар учиртай бэ?

Б.Баярсайхан: Орлогыг төлөвлөхөд их хэцүү байдаг. Яагаад гэвэл тендерээр хоолоо зогоодог учраас яг ямар тендерт орох нь тодорхой бус байдаг.

Цэгмид: Энэ барилга тэр чигээрээ Монинжбар ХК – ийнх биз дээ. Түрээслэгч байгууллагууд байгаа юу? Түрээсээ төлдөг биз дээ. Тэр орлогод ордог уу?

Б.Баярсайхан: Түрээсийн байгууллагууд овоож оойтол орлого оруулаад байдаггүй. Сургууль, доор 2 байгууллага байгаа. Доор байгаа 2 байгууллагын түрээсийн рлого маань гэрэл, ус, цахилгааны төлбөрт явчихдаг. Сургууль бол нэлээд том объектыг түрээслэдэг. Гэхдээ сургуультай хамтын ажиллагаатай ажилладаг. Уг байрны дулааны төлбөрийг төлдөг. Манай ажилчдын хүүхдүүд хөнгөлөлттэй үнээр сурдаг.

Болд: Компани жилд 3 тэрбум төгрөгний ажил гүйцэтгэхэд л боломжийн ашигтай ажиллах юм байна.

Б.Баярсайхан: Ер нь 3 тэрбумаас дээш төгрөгийн ажил гүйцэтгэхэд зардлаа төлөөд гайгүй яваад байдаг.

Хурлын хэлэлцэх асуудал 3

Энэ жилээс нилээд их төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. Нодлингоос эхлээд төр засгийн удирдлагууд инженерийн дэд бүтэц ямар хэрэгтэй бэ гэдгийг ойлгож байна. Үүнтэй холбоотойгоор бидний хийх ажлууд нэлээд нэмэгдэж байна. Ойрын хэдэн жилдээ ажлаар тасрахгүй явах байх.

2017 оны 8 – р сард оролцсон тендер маань 2018 оны 4 – р сарын эхээр ажил шалгарсан тухай мэдэгдлийг авлаа. Бид 14 хоногийн өмнө гэрээгээ байгууллаа. Европын сэргээн босголтын банкны санхүүжилттэй НАБ групп ХХК – тай түншлэлээр гүйцэтгэх ажил юм. Энэ ажил маань яг л мэргэжлийн байгууллагын л хийх ажил. Тасганы усан сангаас Москва хорооллын усан сан хүртэлх Ф600мм – ийн 7050м – ийн урттай цэвэр усны шугамын угсралтын ажил. Энэ ажил маань маш хүнд, маш их саад бартаатай ажил байгаа. Энэ ажлыг хийвэл манай нэр хүнд маш их өснө. Ашгийн хувьд бага ашигтай. Улаанбаатар хотын баруун төвийг усаар хангах төсөл байгаа. Энэ ажил маань бэлтгэл ажилдаа ороод БНХАУ – д импортоор орж ирэх бараагаа захиалаад 2 хүн томилолтоор мөн улаан шугамаа тавьсан, ажил эхлэх зөвшөөрлөө авахаар явж байна. Он дамжсан ажлыг бид энэ оны 11 сардаа багтаагаад гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

Компанийн 2018 онд гүйцэтгэх барилга угсралтын ажил, зарлагдаж буй сонгон шалгаруулалтад оролцоход шаардлагатай байгаа санхүүгийн эх үүсвэр, сонгон шалгаруулалттай холбоотой баталгааны эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор 300 000 000,0 /гурван зуун сая/ төгрөгийн зээлийн шугам, 1,4 тэрбум төгрөгний баталгааны гэрээг харилцагч ХААН банкттай байгуулаад байна.

Болд: Хаан банкнаас зээл авах боломжтой болсон гэсэн үг үү?

Б.Баярсайхан: 1,7 тэрбум төгрөгний эрх олгосон. Үүнээс 300 000 000,0 төгрөгийн зээлийн шугам нээж өгсөн байгаа.

Болд: Ажил эхэлчихвэл санхүүжилтээр тасрахгүй л байх юм уу?

Б.Баярсайхан: Хамгийн гол нь 300 000 000,0 төгрөгийн зээлийн шугам гаргаж өгсөн. Материалын захиалга, урьдчилгаа төлбөр хэзээ орж ирэх үү. Хугацаандаа өгөхгүй бол санхүүгийн хувьд үлгэн салган, хүнд байдалтай явна. Ажлаа зогсоохгүй гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна. БНХАУ – ын олон жил харилцсан компанитайгаа хамтран ажиллаж байна. Энэ ажлын зөвхөн бараа материал, тээврийн зардал 4 тэрбум төгрөг байгаа. Бид энэ ажлаас 500 000 000,0 төгрөгний ашиг харж байгаа ч тооцоолоход бэрх байна.

Болд: Шугам нь авто замаар явж байгаа юу?

Б.Баярсайхан: Ер нь бол тийм. Тасганы овооны гэр хорооллоос гараад Эх нялхасын арын авто замын 1 – р эгнээгээр яваад СОТ- ын байр, 1 – р хороолол гээд маш их бартаатай.

Тендерт ороход маш хүндрэлтэй болсон. Хуучин бол 5-10% - ийг нь өгөөд авдаг байсан бол одоо компаниуд хяналтын үнэнээс хэт доошлуулж үнийн санал өгдөг болоод байгаа. Тендерийн хуулинд хяналтын төсвөөс дээшээ 5%, доошоо 5% - ийн үнийн санал өгнө гэж байсны доошоо 5% - ийн үнийн санал өгнө гэснийг нь хүчингүй болгоод Хамгийн бага үнэ хамгийн сайн тендер байна гэж зааснаас мэргэжлийн бус компаниуд хэт доогуур бараг 50% бууруулж үнийн санал өгдөг болоод байгаа. Энэ нь биднийг зарим тендерт орохгүй байх нөхцөл болоод байна. Бид одоо нэг ажилтай байна. Нэмээд бас 2 тендер авчих юмсан гэж бодоод байна.

Мөн бид энэ барилгынхаа газрыг эргэлтэд оруулах зорилгоор 16 давхар оффис, орон сууцны зориулалттай болгож барихаар Ерөнхий төлөвлөгөөгөөр зураг төсөл батлагдаад байгаа ч

санхүүгийн хувьд асуудалтай байгаа. Хөрш зэргэлдээ “Сан” ХХК, “Улаанбаатар барилга” ХК, манай 3 компани нийлж 3 блок барихаар тохиролцсон. Нийт өртөг нь 40 гаруй тэрбум төгрөг болоод байгаа.

Б.Баярсайхан: Та бүхнээс 2018 оны төлөвлөгөөтэй холбоотой асуух зүйл байна уу? 2018 оны санхүүгийн төслийг батлах уу.

Бүх гишүүд 100% зөвшөөрч ХЭХ-аас 2018 оны санхүүгийн төслийг зөвшөөрсөн тогтоолыг баталлалаа.

Хурлаар хэлэлцэх асуудал 4

2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай холбоотой Ногдол ашиг тараах бололцоо байхгүй байгаа тул 2018 оны 2 – р сарын 28 – ны өдрийн 3 тоот тогтоолоор Ногдол ашиг таарахгүй байх шийвэр гарсан байна./ТУЗ – ийн тогтоолыг танилцуулав/

Б.Баярсайхан: Та бүхнээс тогтоолтой холбоотой асууж лавлах зүйл байна уу? Мөн өөр асуух асуулт, санал хүсэлт байна уу?

Цэгмид: Та бүхэнд 2018 ондоо ажилтай болсонд баяр хүргэе.

Хурлаас гарсан тогтоолыг төслүүдтэй танилцаж батлав. ...

Та бүхнийг хуралдаа хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлж хурал өндөрлөснийг мэдэгдье.

Хурал 12:33 цагт дууслаа.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ТУЗ – ИЙН НАРИЙН БИЧИГ

A blue ink handwritten signature, likely belonging to N. Enkhchuluun.

Н.ЭНХЧУЛУУН